



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/703

Мөрөн сум

Захиалагчийн зарим эрх, үүргийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.2, 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.2 дахь хэсэгт заасан үнэлгээний хороо байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт (ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсөл) бэлтгүүлэх, хянах, баталгаажуулах чиг үүргийг аймгийн Засаг даргын орлогчид хариуцуулсугай.

3. Шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн, өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын орлогч Ц.Гансүх, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Гандэлгэр, Худалдан авах ажиллагааны газрын дарга Б. Должинсорогдог нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР